

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН СЭДЭВ: ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ
БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

**Аудит хийсэн
үндэслэл,
бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” А/100 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэв.

**ХҮҮХДИЙН ХАМГААЛУУЛАХ ЭРХ ХАНГАГДАХГҮЙ, ЗӨРЧИЛ БУУРАХГҮЙ
БАЙНА.**

**Аудитын
тайланг
хүргүүлсэн
байгууллага:**

Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,
аймгийн Засан дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газарт тус тус хүргүүлэв.

Аудитын талаар ерөнхий мэдээлэл

Аудитын зорилт

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх,
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх,
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаанд оролцдог аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын 2019-2023 оны баримт үйл ажиллагааны мэдээ, тайлан, дүгнэлт, баримт материалд зэргийг хамруулсан.

Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаар хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилт, нөхцөл байдлыг хэлэлцүүлэхээр төлөвлөсөн боловч орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотойгоор зохион байгуулах боломжгүй болсон.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ХЭМЖИХ БОЛОМЖТОЙ БАЙДЛААР ТУСГАЖ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХЭД АНХААРАХААР БАЙНА.

Аймгийн бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхой, үр дүнг хэмжиж болохуйц байдлаар тусгах шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын хуулийг 2016 онд мөрдөж эхэлснээс хойш 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 50 орчим журам, 8 стандартыг мөрдөн ажиллаж байгаа хэдий ч журам, стандарт зэргийг боловсруулж, батлах явц удаашралтай байдаг нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг Алсын хараа-2050 хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн адил байдлаар боловсруулж, баталжээ.

Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хүүхдийн эрхийн талаар арга хэмжээг тусгахдаа өмнөх онуудын зөрчилд дүн шинжилгээ хийж, бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтыг тодорхой, үр дүнг хэмжих болохуйц байдлаар тусгах шаардлагатай байна.

Хүүхдийн эрхийн зөрчлийн тоо жил бүр өссөн нь нэг талаараа иргэдийн хууль, эрхийн актын мэдлэг дээшилж буйг харуулж байгаа ч нөгөө талаараа үр нөлөөг сайжруулах арга хэмжээг оновчтой төлөвлөх ёстойг илтгэж байна.

Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр /2017-2021/" нь 0-18 насны хүүхдэд чиглэсэн бөгөөд хүүхдийн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

Энэ хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг аймгийн бодлого, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/027, А/047, А/35 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг аймгийн хэмжээнд 94.0 хувийн биелэлттэй хангуулж ажилласан.
- Эрсдэлт бүлгийн хамгаалал шаардлагатай хүүхдийн мэдээллийн санг бий болгож, 2022 оноос эхлэн Номин даатгалын эрсдэлийн болон хүчирхийллийн даатгалд жил бүр 250-450 хүүхдийг хамруулж, үйлчилгээ үзүүлдэг болсон.
- Эрүүл мэндийн явган аялал, Эрүүл оюутан-ээрэг хандлага, Гүйе Түүе арга хэмжээ, Би хорт зуршилгүй залуу аян, Залуусын сэтгэлийн дархлаа аян, Сургалтын тэтгэлэгт хөтөлбөр, Color of youth, Хөдөлмөр эрхлэхэд хаалгаа нээцгээе үзэсгэлэн худалдаа, Мэргэжил сонголтын аян, Урлагийн наадам, Идэвхэжсэн-2030 төсөл, "Итгэл дэд хөтөлбөр" зэрэг онцлог ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийг аймгийн Засаг даргын 2021 оны А/23 дугаар захирамжаар 14, 2024 оны А/148 дугаар захирамжаар 20 гишүүдтэйгээр тус тус баталсан байна. ХТЗ-ийн үйл ажиллагаа тогтмолжсоноор дараах үр дүн гарсан байна. Үүнд:

- Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, салбар дундын байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж, дүрэмд заасны дагуу жилд нэгээс доошгүй хуралдаж, тайланг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд хүргүүлдэг болсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4 хөгжлийн төвийн үйл ажиллагааны зардал болон эцэг эх, асран хамгаалагчдын нийгмийн даатгалын шимтгэл, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон түр хамгаалах байр, хүүхэд хамгааллын Сайн үйлс төвийн шаардлагатай эх үүсвэрийг аймгийн ИТХ-аар шийдвэрлүүлсэн.

Хүүхдийн төлөө зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд холбогдох байгууллагуудаар дүн шинжилгээ хийлгэж, хүүхэд хамгааллын анхаарах асуудал, чиглэлийг тодорхойлж, шийдвэр гаргаж ажиллах шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэшсэн албан хаагч тогтвортой ажиллуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд анхаарахаар байна.

Аймгийн ХГБХХГ нь хуульд заасны дагуу байгууллагын дүрэм, дотоод журмыг батлан, чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд бүтэц орон тоог ХГБХХЕГ-аас баталсан байна.

Мөн хуулийн 18.2.1-т "нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох" гэж заасныг бүрэн хэрэгжүүлдэггүй ба хүүхэд хамгааллын мэдээлэл, судалгаанд дүн шинжилгээ хийдэггүй, цаашид хийх ажлын чиглэлийг оновчтой тодорхойлоогүй байна.

Хүүхдийн эрх, хамгааллын талаар Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны А/172 дугаар тушаалаар баталсан "Хүүхдийн эрх, хамгааллын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал"-аар сан бүрдүүлж, үйл ажиллагаандаа ашиглах хуулийн зохицуулалттай хэдий ч сан үүсээгүй, үйл ажиллагаандаа ашигладаггүй байна.

Тухайлбал able.mn, 1212.mn, 108.mn, nams.mn цахим системээр нэгтгэдэг бөгөөд эдгээр нь хоорондоо уялддаггүйгээс нэгдсэн сан бүрдээгүй ба тухайн цахим системийг ашиглалт, бүртгэлийн талаар журам, аргачлал гаргаагүй байна.

Хүснэгт 1 Хүүхэд хамгааллын цахим системийн бүртгэлийн мэдээлэл

Цахим систем	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
108.mn	31	58	109	61	112
1212.mn	1,042	1,015	1,051	1,147	1,435
able.mn	30	22	47	1	602

Орхон аймгийн хэмжээнд eoffice.erdenet.mn цахим системээр зорилтот гэр бүл, хүүхдийн бүртгэлийг 2021 оноос эхлэн бүртгэж эхэлсэн ба тоо өссөн дүнгээр мэдээлж, 2024 оны 9 сарын байдлаар 2,973 хүүхдийн бүртгэл үүссэн байна.

Хүснэгт 2 Орхон аймгийн зорилтот гэр бүлийн хүүхдийн цахим системийн бүртгэлийн мэдээлэл

Цахим систем	2021 он	2022 он	2023 он	2024 он	ДҮН
eoffice.erdenet.mn	1,675	427	351	520	2,973

ХГБХХГ-ын бүтэц орон тоог 2022 онд ХГБХХЕГ-ын даргын тушаалаар төрийн захиргааны 10, төрийн үйлчилгээний 18, нийт 28 орон тоотой баталсан ба 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэ бүтцээр ажиллаж эхэлсэн ба "Хүний нөөцийн хөтөлбөр"-ийг боловсруулж, мөрдөн ажиллаж байна.

Нийт албан хаагчдыг ажилласан байдлаар авч үзвэл 5 дээш жил ажилласан 11 буюу 39.2 хувь, 1-5 жил ажилласан 8 буюу 28.7 хувь, 1 жил хүртэл ажилласан 9 буюу 32.1 хувийг эзэлж байгаа ба 2019-2023 онд нийт 52 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөнөөс, өөрийн хүсэлтээр 10, шилжин ажилласан 25, Залуучуудын ордны 17 албан хаагч аймгийн Нийтлэг үйлчилгээний албанд шилжсэн байна. Үүнээс хүүхдийн эрх хамгааллын 6 албан хаагч ажлаас гарсан байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэмд зааснаар 8,000 хүүхдэд нэг хүүхдийн эрхийн байцаагч ажиллахаар заасны дагуу Орхон аймагт 5 байцаагч ажиллахаар атал 1 байцаагч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хүний нөөц тогтвортой ажиллаж байгаа хэдий ч мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, гэр бүл судлаач, сэтгэл засалч зэрэг хүний нөөц дутмаг байна.

Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт тодорхой бус, ерөнхий байгаа нь ажлын ачаалал, ажлын чиг үүргийн хуваарилалтад нөлөөлж байна. Тухайлбал: Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартад зааснаар мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, тогооч орон тоогоор ажиллахаас нийгмийн ажилтан, гэрээт үйлчилгээний ажилтан ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын чиглэлийн орон нутгийн байгууллагын орон тоог тухайн орон нутгийн онцлог, хүүхдийн тоонд харьцуулж тогтоох, мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг албан хаагчийн тоог нэмэгдүүлэх, тогтвортой ажиллуулахад анхаарч, стандартад нийцүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ОНОВЧТОЙ БОЛГОХОД АНХААРАХААР БАЙНА.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүйгээс төсвийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.

ХГБХХГ нь хүүхэд хамгааллын 2019-2023 оны зардлыг төсөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөөр ирсэн байна.

Төсвийн төслийг боловсруулахдаа хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулсан хүүхдийн тоо, судалгаанд үндэслэдэггүй ба 2023 оноос эхлэн хөтөлбөр, зардлын зориулалтаар төлөвлөж эхэлсэн ба төсөвлөлт 2019 оноос 2.2 дахин өссөн байна.

Дүрслэл 1 Хүүхэд хамгааллын зардлын төсвийн төслийн санал, батлагдсан төсөв /мян.төгрөг/




2022 оноос хүүхэд хамгааллын зардлыг тооцож боловсруулахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ийг мөрдөхөөр баталсан боловч 2024 оны төсвийн төсөл боловсруулахад мөрдөж эхэлжээ.

Хүүхэд хамгаалалд зориулсан төсвийг хүүхдийн эрхийн тоон мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээ, судалгаанд үндэслээгүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын батлагдсан төсвийн 18-26 хувийг хүүхэд хамгааллын зардал эзэлж байгаа ба 2019 оноос 1.6 дахин өссөн байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 2 ХГБХХГ-ын батлагдсан төсөв, хүүхэд хамгааллын зардлын харьцаа /мян.төгрөг/



Хүүхэд хамгааллын төсөв нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэдэг бөгөөд хүүхэд хамгааллын зардлын 44.0 хувийг урьдчилан сэргийлэх, 45.0 хувийг хамгаалах нөхөн сэргээх, 5.0 хувийг эрсдэл болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, 6.0 хувийг гэр бүлийн хөгжил хамгааллын зардал эзэлж байна.

Эрсдэлт бүлгийн хүүхдэд давхардсан тоогоор зарцуулсан урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхөн сэргээх зардал жил бүр нэмэгдэж буй ч хүүхэд хамгааллын зөрчил буураагүй нь зөрчлийн шалтгаан, нөхцөл, түүнд үзүүлэх хариу үйлчилгээ бүр харилцан адилгүй бөгөөд журамд тусгаагүй үйлчилгээ, арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага зайлшгүй гарч ирсээр байна.

Дүрслэл 3 Зарцуулсан төсөв, хамруулсан эрсдэлт бүлгийн хүүхдийн тоо /мян.төгрөг/



Цаашид хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төсвийг зарцуулах норматив зардлыг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөцийг орон нутгийн онцлогт тохируулан тогтоож, зардлыг хуваарилах шаардлагатай байна.

ХГБХХГ-ын 28 албан хаагчийн 67.9 хувь нь 5-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллажээ.

"Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэм"-д заасны дагуу хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог батлаагүй, хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартад зааснаар мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, тогооч орон тоогоор ажиллахаас нийгмийн ажилтан, гэрээт үйлчилгээний ажилтан ажиллаж байна.

ХГБХХГ-ын бүтэц, орон тоог орон нутгийн онцлог, түр хамгаалах байрны стандартад нийцүүлэн тогтоож, холбогдох зардлыг хуваарилах шаардлагатай байна.

Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын ил тод байдлыг бүрэн хангаагүй, зарим зардлыг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Орхон аймагт хүүхэд хамгааллын зардалд 2019-2023 онд 594,510.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 534,219.5 мянган төгрөгийг зарцуулжээ. Харин 2022 оноос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хүүхдийн хамгааллын үйлчилгээг сайжруулах аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ыг мөрдсөн байх ба нормативын дагуу 2022, 2023 онд 253,875.2 мянган төгрөг зарцуулсан байна.

2019-2023 онд хийсэн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрч, хэрэгжилтийг бүрэн хангуулж, алдаа зөрчлийг арилган ажилласан ба хүүхэд хамгааллын зардалтай холбоотой алдаа, зөрчил үүсээгүй байна.

Хүснэгт 4 Санхүүгийн тайлангийн аудитын алдаа, зөрчил

Он	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Дүгнэлт
	Тоо	Дүн /мян.төг/	Тоо	Дүн /мян.төг/	Тоо	Дүн /мян.төг/	
2019	3	3,317.2			2	1,694.5	Зөрчилгүй
2020	2	2,829.1	1	719.0	2	202,883.9	Зөрчилгүй
2021			4	2,423.1	4	2,237.5	Зөрчилгүй
2022			1	38,665.2	2		Өөрчлөлтгүй
2023	3	994.0	1	1,200.0	1	14,138.3	Өөрчлөлтгүй

Хүүхэд хамгааллын талаар төсвийн зарцуулалтыг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод тайлагнаж хэвшсэн байна. Харин төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний санхүүжилтийг 5 төрийн бус байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй, зарцуулалтыг ил тод тайлагнаагүй байна.

Дэлхийн Зөн ОУБ-ын Хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт бүртгэлтэй болон бүртгэлгүй 22 өрхийн 76 хүүхэд, 39 насанд хүрэгч шинэ орон гэртэй болж, ковид цар тахлын үед 50 өрхөд 4 удаа хоол хүнсийг 8,400 гаруй хүүхдэд, 160 иргэнд дулаан хүрэм гутал, 20 гаруй өрхөд нүүрс, түлээ зэрэг тусламж үзүүлсэн байна.

Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ гэж хуульд тусгасан.

Манай улсад хүүхэд хамгааллыг гэр бүл, боловсролын салбарын, эрүүл мэндийн үйлчилгээний, хэвлэл, мэдээлэл, цахим орчны, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний, соёл, спортын үйл ажиллагааны гэсэн салбар байдлаар хуульчилсан.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын үйлдэгдсэн орчноор авч үзвэл дараах байдалтай байх ба хүүхдийн эрх, хамгаалал зөрчих гол нөхцөл гэр бүл дэх орчин байна.

Хүснэгт 4 Хүүхэд хамгааллын зөрчил гарсан орчны мэдээлэл

Хүүхэд хамгааллын зөрчил гарсан орчин	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Гэр бүл дэх хүүхэд хамгаалал			131	233	232
Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал	111	182	101	7	25
Боловсролын салбар дах хүүхэд хамгаалал			6	16	15
Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дах хүүхэд хамгаалал			1		2
Соёл, спортын үйл ажиллагаан дах хүүхэд хамгаалал			9	11	1

Аймгийн ХГБХХГ нь сум, багийн нийгмийн ажилтнуудаа тогтмол сургалтад хамруулж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна. Харин багийн нийгмийн ажилтнуудын 22, ЕБС-ийн нийгмийн ажилтны 8 нь мэргэжлийн бус байна.

Энэ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд мэргэшсэн, туршлагатай албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатайг илтгэж байна.

ХГБХХГ нь хүүхэд хамгааллын үйлчилгээ болон зарлагын гүйлгээний баримт, тушаалд хүүхдийн хувь хүний нууцыг хууль, журамд заасны дагуу хамгаалж хэвшсэн, гүйлгээ хийхэд нэр оролцуулаагүй, код ашиглаж байна.

Харин хамтарсан баг, ерөнхий боловсролын сургуулиудад хувь хүний нууц хамгаалах хуулийн хэрэгжилт хангалтгүй, хүүхдийн овог нэр, регистрийн дугаарыг нээлттэй ашиглаж, код үүсгээгүй байна.

Иймд хамтарсан баг, ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хувь хүний нууц хамгаалах хууль, журмын мөрдөх, хөтлөх баримт бичгийн талаар сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ БОДИТОЙ ҮНЭЛЖ ЧАДАХГҮЙ БАЙНА.

Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ хийж, нийгэмд гарах нөлөөллийг тооцдог болмоор байна.

ГБХХЕГ-ын даргын 2020 оны А/240 дүгээр тушаалаар баталсан "Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ыг баталсан ба ХТЗ, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаа хамааралтай байна.

"Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, хүүхдийн эрхийн байцаагч нар 2020 онд ХТЗ, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд, 2023 онд Хүний эрхийн үндэсний комисстой хамтран аймгийн ХТЗ, ХЭХЗХ, хүүхдийн элч, хүүхдийн эрхийн зөрчлийн хэрэгжилтийн байдалд хяналт хэрэгжүүлжээ.

Аймгийн ХТЗ-ийг 12, ХЭХЗХ-г 8, хүүхдийн элчийг 7, хүүхдийн эрхийн зөрчлийн хэрэг шийдвэрлэлтийг 7 үзүүлэлтээр хяналт шалгалт хийж, гарсан үр дүн, нөлөө, тулгамдаж байгаа асуудал, цаашид анхаарах асуудлыг тодорхойлж, зөвлөн тусалсан байна.

Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтэд холбогдох байгууллагууд хяналт үнэлгээ хийдэг боловч зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн үнэлээгүй, хэрэгжилтийн талаар тогтмол судалгаа шинжилгээ хийгээгүй, нэгтгэсэн мэдээллийн сан байхгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын V тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын НБХ гарган хүргүүлсэн ба биелэлтийг 98.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр Дэлхийн зөн ОУБ 2019-2024 оны 08 сар хүртэл, Гүүд нейборс ОУБ нь 2023 оны 05 сараас эхлэн аймагтай хамтран, үйл ажиллагаа явуулж, 2019-2024 онд Эрдэнэт М2М хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор 100 гаруй хүүхдийг дугуйлан клубт хамруулж, 47 хүүхдэд ухаалаг төхөөрөмж, 9 хүүхдэд зөөврийн компьютер, 100 гаруй хүүхдэд хичээлийн хэрэглэгдэхүүн өгч, сурч боловсрох эрхийг нь хангасан байна.

Гүүд нейборс ОУБ нь 2023 оны 05 сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 2 ЕБС-ийн бие засах өрөөг 48,000.0 мянган төгрөг, 1 ЕБС-ийн номын санг 43,000.0 мянган төгрөг, 3 ЕБС-ийн сэтгэл зүйчийн өрөөг 150.0 сая төгрөгөөр тохижуулах төслийг гүйцэтгэсэн байна. Хамтран ажиллах, харилцан ойлголцлын санамж бичигт биелэлтийн үр дүн, тайланг хэлэлцэж, хамтарсан хуралдаанаар дүгнэхээр тусгажээ.

ГБХЗХГ-ын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-аар хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт хяналт хэрэгжүүлэхээр заасан.

ХГБХХГ-ын 2019-2023 оны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, баримтуудад хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн хууль, журам, бодлогын баримт бичиг зэрэгт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, баримт материал байхгүй байна.

ГБХЗХГ-ын даргын 2019 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичигт хүлээсэн чиг үүрэг, зүйл заалт, зорилт арга хэмжээний хүрээнд хүүхдийн хөгжил, хамгаалалд хяналт хэрэгжүүлэхээр заажээ.

Тухайн журмыг үндэслэсэн Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” нь 2020 онд хүчингүй болсон бөгөөд одоог болтол шинэчлээгүй байна. Тус журамд чанарын шалгуур үзүүлэлт, үр нөлөөний үнэлгээг тусгаагүй байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлж, нийгэмд гарч буй нөлөөллийг тооцож чадахгүй байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 21.1 дэх заалтын шалгуур үзүүлэлт, аргачлал батлагдаж гараагүй тул аймгийн ХТЗ-ийн гишүүн байгууллагууд хамтарсан удирдамж гарган хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, дүгнэлт зөвлөмжийг гаргаж ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд гэр бүлийн орчинд анхаарахаар байна.

Аймгийн хэмжээнд байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан гэр бүлийн орчин дах хүүхэд хамгааллыг хэрэгжүүлдэг ба аймгийн хэмжээнд 105 байгууллагын эцэг эхийн зөвлөлийн бодлого үйл ажиллагаа жигдэрч, 7 байгууллага хүүхэд хамгааллын бодлогоо тодорхойлоогүй байна.

Хувийн хэвшлийн байгууллагууд болон томоохон худалдааны төвүүд огт хамрагдаагүй нь хүүхэд хамгааллын тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийн нөлөөг бууруулж буйг харуулж байна.

Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын бодлоготой байгууллагын тоог нэмэгдүүлэх, байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, нөлөөллийн ажлыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 25 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 38 цэцэрлэг үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бүх сургууль, цэцэрлэгт захирал, эрхлэгчээр ахлуулсан хүүхэд хамгааллын баг ажиллаж байна.

БСШУСС-ын 2018 оны А/476 дугаар тушаалаар баталсан “ЕБС-ийн хүүхэд хамгааллын бодлого”, БШУС-ын 2022 оны А/453 дугаар тушаалаар баталсан “ЕБС, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, БСШУСС-ын 2020 оны А/269 дүгээр тушаалаар баталсан “Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэн ажиллаж багш, сурган хүмүүжүүлэгч хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн ажигласан, таамагласан тохиолдолд сургуулийн хүүхэд хамгааллын багт мэдээллийг өгч, сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүд тухайн сурагчийг судлан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, ажлын төлөвлөгөө гарган түүнийгээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд төрийн өмчийн 20 сургуулиас 11 сургууль, хувийн хэвшлийн 5 сургуулиас 1 сургууль, нийт 12 сургуульд хүүхэд хөгжүүлэх, хүүхдийн оролцооны байгууллагын өрөө тасалгааг хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тохижуулж, сурагчдыг өөрсдөө бие даан хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь сургууль бүрийн сургалтын үйл ажиллагааны хуваарь, анги танхимын хүрэлцээнээс шалтгаалж байна.

Аймгийн хэмжээнд 2 сум, 26 багийн хамтарсан багийн бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар ажиллаж байгаа ба 4 ӨЭМТ-д эрүүл мэндийн нийгмийн ажилтантай байна.

Эрүүл мэндийн салбарт хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг, эмч эмнэлгийн ажилтнуудыг хүүхдийн эрх, хамгаалал, хүний эрхийн чиглэлээр сургаж, чадавхжуулах хөтөлбөр байхгүй байсныг ЭМС-ын 2023 оны А/240 тушаалаар “Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгааллын журам”, “Эрүүл мэндийн салбарын үйлчилгээ дэх хүүхэд хамгааллын 2024-2026 оны төлөвлөгөө”-г баталсан байна.

Аймгийн ХТЗ-ийн 2019-2023 оны төлөвлөгөөнд эх хүүхдийн эрүүл мэндийн асуудлаар арга хэмжээнүүдийг төлөвлөн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж, тайланг хэлэлцсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ, СУГ-ын даргын хамтарсан 2022 оны А/242, А/76 тушаалаар баталсан "Соёл спорт, олон нийтийн арга хэмжээнд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн хамгаалах өдөр, гэр бүлийн өдөр, улсын баяр наадмын өдрүүдэд хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг 3-4 байршилд зохион байгуулж, хүүхдийн автобусыг

түрээслэн хүүхдийн тоглоом, зураг зурах, сэтгэл зүйн үйлчилгээ, үзүүлэх орчин бий болгон тохижуулж, эцэг эх асран хамгаалагчаасаа төөрсөн хүүхдүүдийг хүлээн авч, төөрөхөөс урьдчилан сэргийлж, эцэг эхийн утасны дугаар бүхий гарын бугуйвчийг зүүх зэрэг үйлчилгээ үзүүлэн эргэн нэгтгэх ажлыг зохион байгуулж ирсэн байна.

Гамшгийн тухай хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд ХГБХХГ нь "Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын стандарт", "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам", Засаг даргын 2022 оны А/560 тоот захирамжаар "Хүн ам нийгмийн хамгаалалтын алба"-д харьяалагдан гамшгийн үеийн хариу арга хэмжээний төлөвлөлттэйгөөр үүрэг гүйцэтгэх бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Онцгой нөхцөл байдал /ковид-19/-д эрсдэлд өртөх хүүхдүүдийн ар гэрд нөхцөл байдлын үнэлгээг хийж, жил бүр шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлж ирсэн байна.

Аймгийн хэмжээнд үер ус, гал түймэр, ган, зудад нэрвэгдэх өндөр эрсдэлтэй хүүхдүүдийн судалгааг гаргаж, 2019 онд 150, 2020 онд 188, 2021 онд 412, 2023 онд 258 хүүхдийг Номин даатгалын гэнэтийн ослын даатгалд хамруулж, нийт 8,430.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр нөлөө багатайгаас шалтгаалан хүүхэд хамгааллын зөрчил буурахгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын V тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын НБХ гарган хүргүүлсэн ба биелэлтийг 98.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ улсын хэмжээнд 2014 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд улсын хэмжээнд мэдээллийг нэг сувгаар авч, 21 аймаг руу шилжүүлдэг байсан бол 2021 оноос хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний нэгдсэн төв болгон өргөжүүлж, аймгийн ХГБХХГ-ын мэргэжилтнүүдээр дамжуулан 2 сум, 26 багийн нийгмийн ажилтнуудад дуудлагыг шууд шилжүүлдэг болсон байна.

Ингэснээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанар жилээс жилд сайжирч дуудлагын шийдвэрлэлт 99.7 хувьтай байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны судалгаанаас харахад нийт дуудлагын 80 гаруй хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгддэг бөгөөд 19 гаруй хувийг эцэг эх, 12 гаруй хувийг хүүхэд өөрөө, 6 хувийг иргэн, 13 хувийг төрөл садан /өвөө, эмээ, нагац, эгч ах/, 20 гаруй хувийг бусад /хөрш, нийгмийн ажилтан, цагдаа, эмч г.м/ нар өгч байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагч 108 утсанд ирсэн аймгийн дуудлага мэдээлэлд сард тогтмол хяналт, дүгнэлт хийж зөвлөмжийг Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ-т хүргүүлж хэрэгжилтийг хангуулах ажлуудыг зохион байгуулсан байна.

Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга үйлчилгээг хуульд 6 арга хэмжээгээр тусгаж, "MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага", "MNS 6040:2019 Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" үйл ажиллагааг стандартаар баталсан.

Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлж байгаа боловч түр хамгаалах байр стандартад нийцээгүй, орон сууцны дээд давхарт байрлаж байна. Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/ 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж эхлэн 79 хувийн гүйцэтгэлтэй боловч гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалан дуусаагүй байна.

Иймд Хүүхдийн хөгжил хамгааллын төвийн барилгыг дуусгаж, стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эсрэг гэмт хэргийн талаарх арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангуулахад нөлөөллийн ажлууд зохион байгуулж, тайланг тухайн жилийн хуралдаанаар хэлэлцүүлжээ. Тухайлбал:

- 2020 оны аймгийн “Хүүхэд өсвөр үеийнхний дунд донтох эмгэгүүдийн судалгаа хийх”, “Гэмт хэрэгт холбогдох магадлал өндөртэй хүүхдүүдийн судалгааг гаргах” арга хэмжээг төлөвлөн, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Прокурорын газар, Боловсролын газартай хамтран судалгааг гаргаж, 2020 оны 10-р сард ЕБС-уудын дунд болон ахлах ангийн гэмт хэрэгт өртөж болзошгүй сурагчдын эцэг эхэд нөлөөллийн сургалт зохион байгуулан, төрийн болон хувийн хэвшлийн сургуулиудын 5,000 гаруй эцэг эх, асран хамгаалагч хамруулжээ.

- Хүүхдийн гэмт хэргийн суурь шалтгаан нөхцөлийн талаар 2022 онд хийсэн судалгаагаар үе тэнгийнхний дээрэлхэлтийн нөлөөлөл их байдгийг тогтоон, “Ариунсаруулбат” НҮТББ, “Хүчирхийлэлгүй ирээдүй” НҮТББ-тай тус тус гэрээ байгуулж, “Үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх” төслийг хэрэгжүүлсэн байна.

Үе тэнгийнхний дарамт, дээрэлхэлтэд өртөж болзошгүй, үе тэнгийнхэндээ дарамт үзүүлдэг зорилтот 37 хүүхдийг мэргэжлийн сэтгэл зүйн 3 төрлийн үйлчилгээнд холбон зуучилж, гэрээний хэрэгжилтийг “хангалттай” дүгнэсэн байна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр хүүхдүүдийн сэтгэлийн түгшүүр, стресс дарамт буурч, ичгүүр айдас намжиж, эцэг эхчүүд хүүхэд хүмүүжлийн эерэг арга хэмжээ, хүүхдийн насны онцлогт тохирсон сэтгэл зүйн мэдлэг, мэдээлэлтэй болсон үр дүн гарчээ.

Салбар бүрд хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдийг нэгтгэж, дүн шинжилгээ хийсэн гэх боловч статистик тоон үзүүлэлтээр өссөн байна.

Хүүхэд, гэр бүлийн статистик тоон мэдээллийг ОБГ, Цагдаагийн газар, Шүүх, ЭМГ, БОЭТ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, Боловсролын газар зэрэг төрийн байгууллагуудаас улирал, хагас жил тутам авч нэгтгэсэн байна.

4. Аудитын гол дүгнэлт

- Аймгийн бодлогын баримт бичгүүдэд хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхой, үр дүнг хэмжиж болохуйц байдлаар тусгах шаардлагатай байна.
- Хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэшсэн албан хаагч тогтвортой ажиллуулах, мэдээллийн сан бүрдүүлэхэд анхаарахаар байна.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүйгээс төсвийг бодитой тооцож төлөвлөөгүй байна.
- Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтын ил тод байдлыг бүрэн хангаагүй, зарим зардлыг хэмнэлтгүй зарцуулсан байна.
- Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээ хийж, нийгэмд гарах нөлөөллийг тооцдог болмоор байна.
- Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд гэр бүлийн орчинд анхаарахаар байна.
- Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр нөлөө багатайгаас шалтгаалан хүүхэд хамгааллын зөрчил буурахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн даргад:

- Хүүхэд хамгааллын бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд холбогдох салбарын байгууллагуудаар дүн шинжилгээ хийлгэн, анхаарах асуудал, чиглэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдэд зорилго, зорилтыг тодорхой, үр дүнг хэмжиж болохуйц байдлаар тусган, шийдвэрлэж байх,
- 2020 онд барьж эхэлсэн Хүүхдийн хөгжил хамгааллын төвийн барилгын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, ашиглалтад оруулахад онцгой анхаарах.
- Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгайлан Цахим орчин дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, арга хэмжээг тусган, биелэлтэд нь хяналт тавих

Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг дарга нарт:

- Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй хамтарсан багийн албан хаагчдын хоорондын уялдаа холбоог хангаж, ажил үүргийн хуваарьт гүйцэтгэх үүргийг тусган, хариуцлагыг сайжруулах,
- Багийн нийгмийн ажилтнаар мэргэжлийн бус албан хаагч ажиллуулахгүй байх.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт:

- Хамтарсан баг, ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хувь хүний нууц хамгаалах хууль, журмын мөрдөх, хөтлөх баримт бичгийн талаар сургалт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх,
- Эрх бүхий байгууллагаас баталсан журам, аргачлалын дагуу үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүн, үр нөлөөг үнэлж байх,
- Хүүхэд хамгаалал гэр бүлийн орчинд хангалтгүй байгаад анхаарч, нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах,
- Хүүхдийн эрх, хамгааллын статистик бүртгэл, захиргааны маягтыг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэхдээ тулган шалгаж, үнэн зөв байдалд хяналт хэрэгжүүлж, дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааг төлөвлөх.